

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

**СОЦИАЛИСТ ЧИГ БАРИМЖААТ ОРНУУД ДАХЬ
НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВЛӨЛТ****Ц. Баатар**

80-аад оны эхээр социалист чиг баримжаат орнууд үйлдвэрлэх хүчнээ төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх замд шилжин орсон нь эдгээр орны нийгэм-эдийн засгийн амьдралын нэг чухал онцлог шинж болж байна. Дээрх орнуудын нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөө нь эхлээд улсын хөрөнгө оруулалтын программ, улсын төсөвийн орлого зарлагын төсөлтэй зохицуулагдан улсын байгууллагуудын төлөвлөгөөний нэгтгэл хэлбэртэй үүсээд аажимдаа нийт эдийн засгийн хэмжээгээр тодорхой зорилт тавих, улс ардын аж ахуйн үндсэн тэнцвэрт харьцааг тогтоох, үйлдвэрлэлийн өсөлтийн хурдацыг урьдчилан харах зэрэг бололцоо олгож байна. Социалист чиг баримжаат орнуудын төрөөс төлөвлөлтөнд эдийн засгийн программыг боловсруулах болон түүнийг биелүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг багтааж байгаа юм. Тухайлбал: колонийн үлдэгдлийг арилгаж, нийгэм-эдийн засгийн хоцрогдлыг ахар богино хугацаанд даван туулахын тулд аж үйлдвэржих, хөдөө аж ахуйг өөрчлөн байгуулах, улс хоршооллын салбарыг хөгжүүлэх, гадаадын капиталыг улсын болгох, гадаадын болон хувийн капиталын үйл ажиллагаанд хяналт тогтоох, албан татвар, гааль валютын нэгдсэн арга хэмжээ авах, улсын өмчийг өргөтгөх, нийгэм, соёл, шинжлэх ухааныг бүх талаар хөгжүүлэх зэрэг болно.

Социалист чиг баримжаат орнуудын нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөө түүнд тусгагдсан арга хэмжээнүүдээс үзэхэд хувьсгалт ардчилсан хүчин улс ардын аж ахуй дахь тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, эдийн засгийн хөгжлийн хэтийн чиглэлийг төлөвлөх талаар онолын үндэслэлийг боловсруулахдаа төлөвлөгөөтэй төрийн байгууллагагүйгээр социализмыг сэтгэж болшгүй гэсэн В. И. Лениний заалтыг аль нэгэн хэмжээгээр харгалзан үздэг болсон нь харагдаж байна. Гэвч тэдний хувьд төлөвлөх ажлын онолын үндсүүд нь одоохондоо бүрэлдэх үедээ байна.

Социалист чиг баримжаат орнуудад улсын төлөвлөлтийн марксист баримтлалыг боловсруулах нь шинжлэх ухаан-практикийн асар их ач холбогдолтой юм. Төлөвлөлтөнд орсон дээрхи арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд «...машинт аливаа том үйлдвэр буюу социализмын үндэс суурь, материал үйлдвэрлэлийн эх булаг нь үй олон мянган хүний хамтын ажиллагааг чиглүүлэгч зориг санааны яриангүй нарийн чанд нэгдлийг шаардана»¹ гэсэн В. И. Лениний заалт зарчмын чухал ач холбогдолтой. Чухамхүү тийм нарийн чанд нэгдлийг хангасан төлөвлөгөө л нөөцийг дээд зэргээр төвлөрүүлэн ашиглах боломж олгодог болохыг социализмд шилжсэн улс түмний туршлагаас тодорхой харагдаж байна.

¹ В. И. Ленин. Зохиолууд 27-р боть. 283-р тал.

Өнөөгийн үйл явцаас үзэхэд хувьсгалт ардчилсан хүчин төлөвлөлтийн асуудалд янз бүр хандаж байна. Үүнийг бид социалист чиг баримжаат зарим орны жишээн дээр тодорхой авч үзье.

Алжирийн хувьсгалт ардчилсан хүч төлөвлөлтөнд их анхаарах болжээ. Тэдний үзэл санаа нь Алжирийн хувьсгалын программчилсан баримт бичиг болох Үндэсний Хартид тусгалаа олжээ. Зөвхөн шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөгөө л улс орныг харьцангуй богино хугацаанд үйлдвэржүүлэх, нэн чухал нөөц бололцоог дайчлах, түүний хуваарилалтыг төлөвлөх, шаардлагагүй зарлагатай тэмцэх зорилтыг хангаж чадна² гэж үзжээ. Ийм ч учраас тэд өөрсдийн төлөвлөгөөг шинжлэх ухааны шинж чанартай болгохыг чармайх болов. Алжирт 1956—1966 онд зохиогдсон 10 жилийн төлөвлөгөөг бусад төлөвлөгөөнүүдээс хамгийн сайн үндэслэлтэй зохиогдсон гэж улс орны дотоодод ч, гадаадын судлаачид ч нэгэн адил тэмдэглэж байна. Өнгөрсөн оны сүүлчээр хуралдсан Алжирийн Үндэсний Чөлөөлөх фронт Намын V их хурал тус орны нийгэм-эдийн засгийг 1985—1989 онд хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөний үндсэн чиглэлийг баталж 2000 он хүртэлх үндэсний өөрчлөлтийн зорилтыг төлөвлөв.³

Шинэ таван жилийн төлөвлөгөөний үндсэн чиглэл нь аж үйлдвэрт улсын салбарыг цаашид улам бэхжүүлэх, эдийн засгийн салбаруудын тэнцвэрт хөгжлийг хангах, өрнөдийн орнуудын хамаарлыг сулруулах, газар тариалангийн шинэчлэлийг гүнзгийрүүлэх, үндэсний боловсон хүчнийг бэхжүүлэхэд чиглэгджээ.

Афганистан 1979 оноос эхлэн улс орныхоо нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөнд шилжлээ. Түүнчлэн 1985 он хүртэл улс орны нийгэм-эдийн засгийн өөрчлөн байгуулах шинжлэх ухааны үндэслэлтэй хэтийн төлөвлөгөө боловсруулав.

Өмнөд Йемен мөн таван жилийн төлөвлөгөөгөөр хөгжиж байна. Үүний үр дүнд анхдугаар таван жилийн эцэст эдийн засгийн улсын салбарын эзлэх хувийн жин хоёр дахин, хоршооллын салбарт эзлэх хувийн жин 1,5 дахин нэмэгдэв.⁴ Йемений улс ардын аж ахуйг 1981—1985 онд хөгжүүлэх II таван жилийн төлөвлөгөө нь Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөлийн гишүүн орнуудын төлөвлөгөөтэй уялдуулан зохицуулснаараа онцлог юм. Ингэж зохицуулсан явдал тус орны социалист чиг баримжааны замаар урагшлан хөгжих илүү таатай нөхцөл бий болгож байна.

Кампучийн Ардын Хувьсгалт Нам (КАХН) хувьсгалт зорилтыг шийдвэрлэхдээ улс орныхоо бодит байдал, үндэсний онцлог боломжийг харгалзан социализмд аажмаар шилжих замыг сонгон авсан юм. КАХН социализмд аажмаар шилжих зорилтыг шийдвэрлэх үндсэн шижим нь тус орны эдийн засгийг төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх явдал гэж үзээд улс орны ойрын таван жилд (1981—1985) хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулан баталж, түүнийг хэрэгжүүлэх талаар доривтой амжилт олж байна.

Мадагаскарт төлөвлөгөө улсын болон хоршооллын бүх салбарт нэвтэрчээ. Тус орны хэтийн төлөвлөгөө нь гурван үндсэн үе шаттай. 1978—1984 онд аж үйлдвэрийн гол салбарыг бий болгох, 1985—1993 онд эдийн засагт социализмын үндсийг бэхжүүлж аж үйлдвэрийн

² Национальная хартия Алжирской Народной Демократической Республики. М., 1979, с. 43-44.

³ «Үнэн». 1983 оны 12-р сарын 24. № 307

⁴ В. Д. Попов. Экономическое сотрудничество стран СЭВ с развивающимися государствами М., 1982. с. 99.

шинэ шинэ салбар бий болох, 1994—2000 онд Мадагаскарыг хөгжилтэй аж үйлдвэрийн орон болгохоор тус тус төлөвлөжээ⁵.

Этиопийн төвлөрсөн төлөвлөлтийн дээд зөвлөл улс ардын аж ахуйн салбаруудын хөгжлийг зохицуулан эдийн засаг, соёлыг хөгжүүлэхэд нийт үндэсний хувьсгалт компанийг чиглүүлж байна. Анголын МПЛА Намын I их хурал Анголын нийгэм-эдийн засгийг 1976—1980 онд хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөний үндсэн чиглэлийг баталсан юм. Түүнд өнөөгийн үе шатны үндсэн чиглэл нь эдийн засгийн жинхэнэ тусгаар тогтнолыг хангах улмаар төлөвлөгөөт хөгжлийн үндсэн дээр социализмд шилжих эдийн засаг-техникийн бааз байгуулах явдал юм гэж тодорхойлжээ. МПЛА Нам өмнөх төлөвлөлтөндөө үндэслэн тус орны нийгэм-эдийн засгийг 1980—1985, 1985—1990 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан баталж, түүнийгээ хэрэгжүүлэх талаар их зүйл хийж байна.

Мозамбикт одоогийн байдлаар эдийн засгийн үйл ажиллагааны 75 хувь нь жилийн төлөвлөгөөгөөр зохицуулагдах болов.

Гвинейн ерөнхийлөгч агсан Секу Туре аж ахуйн бодлогод эдийн засгийн төлөвлөлт онцгой чухал ач холбогдолтойг нэг бус удаа тэмдэглэжээ.⁶ Гвинейн нийгэм-эдийн засгийг хөгжүүлэхээр 1960—1963, 1964—1970 онд тус тус боловсруулсан төлөвлөлтийн практиктаа үндэслэн 1973 оноос таван жилийн төлөвлөгөө зохион хэрэгжүүлж ирэв. Үүний үр дүнд сүүлийн 15 жилд улс орныхоо эдийн засгийн чадамжийг ихээхэн нэмэгдүүлжээ. Социалист хөгжлийн замыг хангах зорилгоор Гвинейн хувьсгалт үндэсний зөвлөлийн 46-р чуулганаар Гвинейн ард түмний амьдралын түвшинг дээшлүүлж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн түвшинг дээшлүүлэх эдийн засаг-техникийн бааз байгуулах гол зорилтыг дэвшүүлсэн Гвинейн нийгэм эдийн засгийг 1981—1986 онд хөгжүүлэх IV таван жилийн төлөвлөгөө боловсруулан баталжээ. Одоо түүнийгээ нийгмийн амьдралд хэрэгжүүлж байна.

Танзанийн ерөнхийлөгч Ж. Ньерере «Манай улс одоо хөгжлийн доод түвшинд байна. Сайн сайхан ирээдүйд хүрэх манай хөгжлийн цорын ганц зам бол нөр хичээнгүй хөдөлмөр, бодож боловсруулсан төлөвлөгөө л чухал»⁷ гэж онцлон тэмдэглэжээ.

Тэгээд ч Танзанид төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй болгох талаар их ажил хийгдэж байна. Тухайлбал, 1961—1964 онд хэрэгжүүлсэн гурван жилийн төлөвлөгөөний гол зорилт нь хүн амын мөнгөн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бол 1964—1969 онд нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөөг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэх, Танзанийн нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх II таван жилийн (1969--1974), III таван жилд (1977—1981) голчлон хөдөө аж ахуйг хөгжүүлэх зорилт тавьжээ.

Түүнчлэн Танзанийн хувьсгалт ардчилсан удирдлага улс орныхоо нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх 20 жилийн хэтийн төлөвлөгөөг боловсруулан баталж түүнийг 1975 оноос эхлэн мөрдөж ирэв. Ингэж хэтийн төлөвлөлөгөө боловсруулсан нь улс ардын аж ахуйн хоцрогдлыг арилгах, зорилтыг хэрэгжүүлэхэд зохих үр дүнгээ өгч байна.

Уг төлөвлөгөөнд Танзанид аж үйлдвэрийг хөгжүүлэх 5 үндсэн арга зам байна гэж тодорхойлжээ. Үүнд, хамгийн их өсөлтийн чиглэл, аж үйлдвэрийн үндсэн салбарыг хөгжүүлэх чиглэл, хөдөө аж ахуйн жи-

⁵ А. С. Григорьев. Научный социализм и современная революционная демократия Львов. 1982., с. 72.

⁶ Секу Туре. Независимая Гвинея. М., 1960.

⁷ Nyerere J. K. Freedom and Socialism. A Selection from Urutings and Spaches. 1965-1967. Dar es Salaam, 1968. p. 404

жиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэл, Дорнод Африкийн хөгжлийн чиглэл (бүс нутгийн төлөвлөлттэй уялдуулах –Ц. Б.), олон салбарт аж ахуйг хөгжүүлэх чиглэл юм. Дээрх арга замыг хэрэгжүүлснээр улс орны хэрэгцээг хангах илүү таатай нөхцөл бүрэлдэх болон гэж үзэж байна.⁸ Бирмийн эдийн засгийн төлөвлөлтийн гол зорилго нь ард түмний материаллаг аж байдал нийгэм соёлын хэрэгцээг хангахад чиглэгджээ. Энэ зорилт 1971 онд хуралдсан Бирмийн социалист программын намын I их хурлын тогтоолд тусгагджээ. Тус их хурлаас үндэсний эдийн засагт шинэ нийгмийн үндэс суурийг тавих зорилгоорөөрчлөн байгуулалтын 20 жилийн төлөвлөгөө баталжээ. Дээрх баримт бичгүүдээс үзэхэд хувьсгалт ардчилсан хүчин төлөвлөлтөнд хандах хандлага, түүнийг боловсруулан баталж нийгэм-эдийн засгийн амьдралд хэрэгжүүлж буй үйл явц харилцан адилгүй байгаа боловч социалист чиг баримжаат орны төлөвлөлт дараах үндсэн үүргийг гүйцэтгэж байна гэж үзэх бүрэн үндэстэй. Нэгдүгээрт, төрийн эдийн засгийн бодлогыг илэрхийлэх хэрэгсэл: хоёрдугаарт, санхүү, материал, хөдөлмөрийн нөөцийг дайчлах хэрэгсэл: гуравдугаарт, үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх хэрэгсэл:дөрөвдүгээрт нийгмийг хувьсгалт ёсоор өөрчлөх хэрэгсэл болж байна.

Социалист чиг баримжаат орнуудын төлөвлөлт үндэсний эдийн засгийн зонхилох өндөрлөгийг эзэлж байгаа улс, хоршооллын салбарт төвлөрчээ.

Өгүүлэн буй орнуудын төлөвлөлт, зохицуулалт нь улсын салбарын зохион байгуулалт бүтцийг сайжруулах, хэмжээг нь өргөтгөх замаар капиталист үйлдвэрлэлийн харилцааны (зарим оронд түүнээс өмнөх Ц. Б.) өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийг, дараа нь энгийн нөхөн үйлдвэрлэлийг ч гэсэн бүх талаар хязгаарлахад чиглэгдэх болов.⁹

Энэхүү төлөвлөгөө нь уул орны төрийн шинж чанар тухайлбал төлөвлөгөөт зорилтыг дэвшүүлэх, хэрэгжүүлэх хүчний ангийн шинж чанараас шууд хамаарч байгаа учраас төлөвлөгөөний далайц нь нийгэм-эдийн засгийн өөрчлөлтийн хир хэмжээтэй холбоотой бөгөөд түүний шууд нөлөөллийн дор зохиогдож байна.¹⁰

Нэгэнт батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд объектив, субъектив олон хүчин зүйл нөлөөлж байгаа нь мэдээж. Тугайлбал, эдийн засгийн олон хэвшилт шинж чанар улс ардын аж ахуйд улс хоршооллын салбарын эзэлж буй байр суурь төрийн нийгмийн шинж, эдийн засгийн хөгжлийн хүрсэн түвшин, хуримтлалын дотоод эх булгийн хязгаарлагдмал байдал, гадаад нөхцөл, төлөвлөгөөний чанар чансаа, статистик тооцооны чадавхи, боловсон хүчний хэр хэмжээ зэрэг хүчин зүйлээс ихээхэн шалтгаална.

Социалист чиг баримжаат орнуудад зохиогдсон төлөвлөгөө нь дээрх хүчин зүйлээс шалтгаалан программчилсан лоозон төдийгөөр өнгөрөх явдал байгааг олж харж болно. Үүнээс болоод төдөвлөгөө биелэхгүй явдал гарч байна.

Аж үйлдвэр, газар тариалан хөгжөөгүй, мал аж ахуй материаллаг үйлдвэрлэлийн дагнасан салбар байсан Монгол орны өвөрмөц нөхцөлд В. И. Лениний хоршооллын төлөвлөгөө тус орны нийгэм-эдийн засгийг капиталист биш хөгжлийн замаар хөгжүүлэх шинжлэх ухаа-

⁸ Economic QUARTERLY institute for the Economy of Developing countries “Bruno LEUSCHNER” Berlin-GDR. Volume 18. Number 3, 1983. p. 3-13

⁹ Государственный сектор и социально-экономический прогресс в развивающихся странах. Киев. 1980. с. 111.

¹⁰ Н. Дангаасүрэн. «Гуравдахь ертөнц» эдийн засгийн тусгаар тогтнолын асуудал. УБ., 1977, 167-р тал.

ны үндэслэлтэй социалист төлөвлөлтийн эх суурийг тавьж өгсөн юм.

Ю. Цэдэнбал: «1921 онд газрыг улсын өмч болгож, бас эд хэрэглэгчдийн хоршоо байгуулсан нь тус орны эдийн засагт улс хоршооллын салбарын эх үүсвэр бий болсон юм»¹¹ гэж дүгнэжээ.

БНМАУ-ын капиталист биш хөгжлийн туршлагаас үзэхэд шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөгөөг дэвшүүлсний дараа түүнийг жинхэнэ ёсоор хэрэгжүүлэх үйлст хөдөлмөрчин олныг өргөнөөр зохион байгуулж төр, олон нийтийн бүх байгууллагын үйл ажиллагааг энэ зүгт чиглүүлэх асуудал манай намын эдийн засгийн бодлогын цөм нь байжээ.

Шинэ тулгар хөгжиж байгаа орнуудын нийгмийн дэвшилд тус дөхөм үзүүлэх зорилгоор БНМАУ, хөгжлийн капиталист биш замын түүхэн туршлагадаа үндэслэн олон чухал асуудлуудыг санаачлан боловсруулж НҮБ, түүний салсар байгууллагын хурал чуулганаар удаа дараа хэлэлцүүлэн батлуулж ирэв. Тухайлбал, «нийгмийн дэвшлийн үүднээс нийгэм-эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлт хийх үндэсний туршлагын тухай тогтоолыг өнгөрсөн онд хуралдсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 38-р чуулганаар батлуулав.»¹²

Социалист чиг баримжаат орнуудын хувьсгалт ардчилсан хүчин орчин үеийн шинжлэх ухаан-техникийн дэвшилтэй уялдан дотооддоо болон олон улсын эдийн засгийн байдалд гарч болох өөрчлөлтийг харгалзан улс орны нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх, аж ахуйгаа өөд нь татах хэд хэдэн төлөвлөгөөний төслийг капиталист, социалист орнууд болон НҮБ-ын эдийн засгийн комисс, бүсийн эдийн засгийн комиссууд, Шинэчлэлт хөгжлийн олон улсын банк, Олон улсын хөгжлийн холбоо, Хүнс хөдөө аж ахуйн байгууллага зэрэг олон байгууллагын оролцоотойгоор боловсруулан тэдгээрийн дотроос хөгжлийн түвшинг хамгийн амжилттай дээшлүүлэхүйцийг нь шилж авах туршлага бий болов. Тэдгээрийн тус тусдаа зохиосон төлөвлөгөөний төсөл нь империалист, социалист эсрэг тэсрэг хоёр бодлогын тод илрэл болж байна. Тухайлбал, Алжирийн эдийн засгийн төдөвлөгөөний төсөл зохиосон АНУ, Францын мэргэжилтнүүд Алжирт хөдөө аж ахуйг голчлон хөгжүүлэхэд тохиромжтой гэсэн дүгнэлт хийжээ. ЗСБНХУ-ын мэргэжилтнүүдийн зохиосон төсөлд Алжирийн тодорхой нөхцөл, хөгжлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөвтэй холбон улс ардын аж ахуйг төлөвлөгөөтэй хөгжлийн үндсэн дээр өөрчлөн байгуулах, үндэсний аж үйлдвэрийг хөгжүүлэн, хөгжингүй орнуудыг гүйцэх зарчмыг удирдлага болгосон байна. Иймээс Алжирийн засгийн газар ЗСБНХУ-ын мэргэжилтнүүдийн боловсруулсан төслийн үндсэн дээр төлөвлөгөөгөө зохиожээ. Сүүлийн үед ЗХУ болон ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд хөгжиж байгаа түүний дотор социалист чиг баримжаат орнуудын хооронд тогтсон олон талт хамтын ажиллагааны үр дүнд төлөвлөлтийн салбар дахь хамтын ажиллагаа өргөжив. Тухайлбал 60-80-аад онд ЗХУ-ын мэргэжилтнүүд Алжир, Конго, Афганистан, Өмнөд Йемен, Ангол, Этиоп зэрэг олон орны төлөвлөгөө зохиоход оролцжээ.¹³ ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн орноос социалист чиг баримжаат орнуудын нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх шинжлэх ухааны үндэстэй төлөвлөгөөг хамтран боловсруулах явдал ийнхүү өргөжиж байгаа нь эдгээр орны хүн амд оногдох орлогыг түргэн нэмэгдүүлэх, ажилгүйдлийг арилгах, үнийн харьцангуй тогтвортой түвшинг барих, төлбөрийн тоо-

¹¹ Ю. Цэдэнбал. Социалист Монголын хөгжил дэвшлийн түүхэн замнал. УБ., 1976, 225-р тал.

¹² «Үнэн» 1983 оны 11-р сарын 30.

¹³ В. Д. Попов. Экономическое сотрудничество стран СЭВ с развивающимися государствами. М., 1982, с. 95.

цооны тэнцвэрийг хадгалах, орлого хуваарилалтын тэнцвэргүй байдлыг багасгах, муж хязгаарын хөгжлийн хэт ялгааг хөгжлийн түргэн ахицаар ойртуулах, эдийн засгийн олон талт харилцан уялдан зохицуулагдсан хөгжлийг бий болгох зэрэг олон асуудлыг нэгтгэн чиглүүлэх, энэ үндсэн дээр нийгмийн бүх талаар эрчимтэй жигд дэвшилтийн нөхцөлөөр хангах, дотоод гадаадын болзошгүй нөлөө, дагавраас хамаарах бэрхшээлийг уян хатнаар даван туулах чухал нэмэгдэл бололцоог урьдчилан харах өргөн боломж болгож байна.

Энэ бүхнээс үзэхэд социалист чиг баримжаат орнуудын хувьсгалт-ардчилсан төр нь улс орныхоо нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх үйл явцдаа аж ахуйг эрхлэн хөтлөх социалист арга, энэ талаар социализмын орнуудын хуримтлуулсан баялаг туршлагыг хэрхэн бүтээлчээр хэрэгжүүлснээс ихээхэн шалтгаална. Төлөвлөлтийг ингэж улс орны нийгэм-эдийн засгийг удирдан хөгжүүлэх үр ашигтай хэрэглүүр болгон хувиргах нь социалист чиг баримжаат орны хувьсгалт ардчилсан хүчний гол зорилтын нэг мөн.

СОЦИАЛЬНО-ЭКОНОМИЧЕСКОЕ ПЛАНИРОВАНИЕ В СТРАНАХ СОЦИАЛИСТИЧЕСКОЙ ОРИЕНТАЦИИ

(Резюме)

Ц. Баатар

В статье рассматриваются проблемы и перспективы социально-экономического планирования в странах социалистической ориентации.

Начиная с 80-х годов эти страны перешли к планированному развитию производственных сил. Подобное планирование создает условия для совершенствования программы капиталовложений, сохранения баланса доходов и расходов государственного бюджета и развития производственных отношений в народном хозяйстве.

Естественно, этот процесс происходит в разных странах по разному. В статье подробно отмечаются особенности национального развития на примере отдельных стран социалистической ориентации (Алжир, Афганистан, Южный Йемен, Кампучии и др.). В этих странах, несмотря на их несхожие исторические предпосылки планирование играет следующую роль: во-первых, оно является средством выражения государственной экономической политики; во-вторых, средством привлечения финансовых, материальных и трудовых ресурсов; в-третьих, средством развития производственных сил; в-четвертых, средством революционного преобразования общества.

Планирование в странах социалистической ориентации централизовано в кооперативном секторе, занимающего в экономике этих стран главное место.

В последнее время между СССР, странами-членами СЭВ и развивающимися странами развивается сотрудничество в области планирования. Специалисты социалистических стран помогают разрабатывать

и совершенствовать планы национального развития развивающихся стран на основе достижений науки и накопленного опыта. Особое значение может иметь опыт некапиталистического развития МНР, которая за короткий исторический срок при помощи социалистических стран достигла успехов в социалистическом строительстве.

Правильное планирование развития общества и экономики в странах социалистической ориентации в большой степени зависит от творческого применения социалистического способа ведения хозяйства и использования при этом опыта социалистических стран. Использование планирования в качестве эффективного средства управления и развития экономики является главной задачей революционно-демократических сил в странах социалистической ориентации.